



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 02

Номгон

Г Эрүүл аюулгүй-Цэвэр орчин бүрдүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн Хог хаягдлын менежментийг сайжруулах, хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тогтолцоог эрчимжүүлж, орчны бохирдлыг бууруулах, усны сан бүхий газрыг бохирдохоос хамгаалах, эрүүл аюулгүй, цэвэр орчныг бүрдүүлэх, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02, 05 дугаар албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

**Нэг. Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга нарт даалгах нь:**

1.1.Хаврын улирал эхэлсэнтэй холбогдуулан шар усны үерээс хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд гэр хорооллын бүсийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, бүх нийтийн цэвэрлэгээг сар бүр зохион байгуулах

1.2.Орон нутагт эвент арга хэмжээ зохион байгуулахдаа талбайгаас 500м-ээс доошгүй зайд автомашины зогсоолын талбай, энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хог хаягдлын цэг, байгаль орчинд ээлтэй ариун цэврийн байгууламжийг байрлуулж тэмдэгжүүлсэн байх

1.3.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, үүсгэгч нь хариуцах, санхүүжилт, урамшууллын системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх

1.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, өдөр бүр тогтсон цэгт хаях, хог хаягдал шатаах, автомашин ил задгай угаах, гудамж талбайд нус, шүлс, цэр, тамхины иш хаяхгүй байх, орчны

1230134

бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар уриалах болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх хог хаягдлыг бууруулах, нүхэн жорлонг ашиглалтаас хасах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахимаар тогтмол сурталчлах

1.5.Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих, нутаг дэвсгэрийн хэмжээнд хадгалагдаж байгаа аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх

1.6.Харьяалах нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг "Мал амьтны хүүр, сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 6406:2013 стандарт"-ын дагуу зохион байгуулах

1.7.Баянхонгор, Жинст, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баацагаан, Эрдэнэцогт сумын Засаг дарга нар сумын хог хаягдлын цэгийг хумих, цэгцлэх, булшлах арга хэмжээ авах

1.8.Усны эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтад авах, хамгаалалтын бүсийн заагийг тогтоох

1.9.Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, хамгаалах, тохижуулах, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах

1.10.Хөрсний нян, бактери, хүнд металлын бохирдлын түвшинг тогтоох судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах

1.11.Улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний цэгүүдийн нүхэн жорлонг ашиглалтаас гарган буулгаж, хөрсийг нөхөн сэргээх арга хэмжээ авч, Нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага MNS 4943:2011 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох

1.12.Хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний тооллого зохион байгуулж, Гэр хорооллын нүхэн жорлонд тавигдах шаардлага MNS 5924:2019 шаардлага хангуулж, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлж эко жорлонтой болгох арга хэмжээг авах

1.13.Аймаг, сумын төвд MNS 4943:2011 стандартын шаардлага хангасан нийтийн ариун цэврийн байгууламжийн тоог нэмж байгуулах

1.14.Аймаг, сумын үйлчилгээний бүх байгууллагуудыг ариун цэврийн өрөөг үнэ төлбөргүй, нээлттэй болгож, иргэд, жуулчид чөлөөтэй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх

1.15.Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй худалдаа үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг MNS 4943:2011 стандартын шаардлага хангуулах

1.16.Аялал жуулчлалын баазуудын нүхэн жорлонг буулгаж MNS 5924:2019 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох

1.17.Автозасвар, тос тосолгооны төв, автомашины угаалгын газар, хүнсний болон барааны зах, худалдааны төв, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах, эрүүл ахуй ариун цэврийн шаардлагуудыг хангуулах, ариун цэврийн байгууламжуудыг стандартад нийцүүлэх, стандартын хэрэгжилтэд тогтмол хяналт тавих

1.18.Автозасварын төвүүдийг саарал ус ашиглах технологи санаачилгыг дэмжих

1.19.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах

***Хоёр.Байгаль орчин, аялал жуулчлалын газарт даалгах нь:***

2.1.Сав газрын захиргаадтай хамтран усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг тогтоож, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах

2.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, өдөр бүр тогтсон цэгт хаях, хог хаягдал шатаах, автомашин ил задгай угаах, гудамж талбайд нус, шүлс, цэр, тамхины иш хаяхгүй байх, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар уриалах болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх хог хаягдлыг бууруулах, нүхэн жорлонг ашиглалтаас хасах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахимаар тогтмол сурталчлах

2.3.Ариун цэврийн байгууламжийн стандартуудын талаарх зөвлөмж, чиглэлийг сумын Засаг дарга болон аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт хүргүүлэх

2.4.Хог хаягдлын менежментийн талаарх сургалт, нөлөөллийн ажил арга хэмжээг бүх төрийн байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулах

2.5.Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт, албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангах

***Гурав.Боловсрол, шинжлэх ухааны газарт даалгах нь:***

3.1.Бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан хог хаягдлын менежментийн боловсролыг иргэд, олон нийтэд олгох

3.2.Бага насны хүүхэд, ерөнхий боловсролын сурагчдад багаас нь хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг төлөвшүүлэх

***Дөрөв.Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанд даалгах нь:***

4.1.Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг тогтоож, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах

4.2.Усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс дагуух хог хаягдлын цэвэрлэгээг сумын Засаг дарга нартай хамтран тогтмол зохион байгуулах

4.3.Усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс дагуух нүхэн жорлонг буулгаж, стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгох

***Тав."Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГазарт даалгах нь:***

5.1.Аймгийн төвийн зам дагуух хашлага хайс болон нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол зохион байгуулж, ил задгай хог хаягдалгүй байх

5.2.Зам дагуух хашлага хайс, цэцэрлэгт хүрээлэн, парк, нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь хог хаягдлын сав, сандал болон бусад тохижилтын материалыг угааж цэвэрлэн өнгө үзэмжийг сайжруулах

***Зургаа."Цэвэр хот" ОНӨААТҮГазарт даалгах нь:***

6.1.Хог хаягдлын цэвэрлэгээ, тээвэрлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулж, эрүүл аюулгүй, цэвэр орчин бий болгох

6.2.Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулж, зөвхөн ангилан ялгасан хог хаягдлыг ачиж байх хэвшлийг бий болгох;

***Долоо.Төрийн болон орон нутгийн өмчит, төсөвт байгууллагын дарга нар болон Аж ахуй нэгж байгууллагуудад:***

7.1.Хаврын улирал эхэлсэнтэй холбогдуулан шар усны үерээс хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сар бүр зохион байгуулах бүх нийтийн цэвэрлэгээнд бүх шатны ажилтан, албан хаагчдыг оролцуулах

7.2.Өөрийн байгууллага болон орон, байрны гаднах цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, ил задгай хог хаягдалгүй байх

7.3.Өөрийн байгууллагатаа хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжтой хогийн савыг байршуулах

7.4.Харьяалах нутаг дэвсгэрийнхээ хог тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ангилан ялгасан хогийг тээвэрлүүлэх

7.5.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжийг бүрдүүлж, хогийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин ашиглах

7.6.Үйлчилгээний бүх байгууллагууд ариун цэврийн өрөөгөө үнэ төлбөргүй, нээлттэй болгож, иргэд, жуулчид чөлөөтэй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх

7.7.Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй худалдаа үйлчилгээний байгууллагууд нүхэн жорлонгоо нэн даруй буулгаж MNS 4943:2011 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болох

7.8.Аялал жуулчлалын баазууд нүхэн жорлонгоо нэн даруй буулгаж MNS 5924:2019 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох

7.9.Автозасвар, тос тосолгооны төв, автомашины угаалгын газар, хүнсний болон барааны зах, худалдааны төв, үйлчилгээний байгууллагууд байгаль орчин, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан үйл ажиллагаа эрхэлж, ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлэх

### ***Найм.Ард иргэдэд***

8.1.Сум,багаас зохион байгуулсан олон нийтийн ажилд идэвхтэй оролцон, хог хаягдлыг ангилан ялгах, ил задгай талбайд хог хаягдлыг асгахгүй байхад анхаарч Үндсэн хуульд заасан иргэнийхээ үүргийг нэр төртэй биелүүлэх

8.2.Залуу хойч үедээ Байгаль орчноо хамгаалах, хог хаягдлаа ангилан ялгах, ил задгай газар хог хаягдал хаяхгүй байх талаар зөв дадал хэвшүүлэхэд үлгэрлэн ажиллах

8.3.Сар бүр зохион байгуулах бүх нийтийн цэвэрлэгээний үеэр өөрийн өмчлөл, эзэмшлийн хашаа болон оршин сууж буй орон сууцны гаднах талбайг цэвэрлэж эрүүл аюулгүй, цэвэр орчныг бүрдүүлэх

**Ес.** Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан сар бүрийн 20-ны өдрийн дотор тухайн сард авч

хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг, холбогдох нотлох баримт, зургийг хавсарган Баянхонгор аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (<https://bayankhongor.igovernment.mn/>)-д тайлагнахыг Сумдын Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг), Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа (Б.Ням-Очир), “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ (Т.Отгонбаатар), “Цэвэр хот” ОНӨААТҮГ (Ц.Баясгалан), аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

**Арав.** Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН